



Ардын өв уламжлал

МОНГОЛ АРДЫН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ӨВ УЛАМЖЛАЛЫГ СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛД АШИГЛАХ НЬ

Хүн төрөлхтөний амьдрах ёс адил хэдий ч монгол хүний амьдрах ёс заншил өөрийн гэсэн онцлогтой. Бидний амьдарч, ажиллаж байгаа орчин нөхцөл байгаль цаг уур, нүүдэлчин Монголын соёл иргэншил бусад орныхоос ялгаатай.

Хүнийг сургаж хүмүүжүүлэхэд таньж мэдэх, хүний зан маягийг судалж сурахад шинжлэх ухааны олон нээлт бүтээлүүд тусалдаг.

Эдгээр нээлт нь гагцхүү амьтан бодгаль гэдгээр судалж, танин мэдүүлдэг бол ардын сурган хүмүүжүүлэх ухаан нь тухайн үндэстэн ястны үүсч хөгжсөн түүхийн урт удаан хугацааны амьдралын туршлага, зан заншил амьдрах, хөдөлмөрлөх өвөрмөц онцлогоор нь үе дамжуулан сургаснаар хэрэгждэг учир бид үүнийг орхигдуулж болохгүй.

Нийгмийн хөгжил бүхэн өөртөө өвлөн авсан тулгуурлах уламжлалын зэрэгцээ цаашид түүнийг баяжуулах хэрэгцээтэй байдаг бөгөөд өөрчлөлт, шинэчлэл бүхэн тухайн зөрчлийг даван туулж хөгждөг зүй тогтолтой. Ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалын үндэс нь ард түмний олон зуун жилийн туршид бий болгож бүтээсэн оюун санааны болон ахуй орчны цогц юм. Монголын малчин ардын ахуй амьдрал, аж төрөх ёс, эрх чөлөөний тэмцлээс урган гарсан хүмүүжлийн эрхэм дээд эрмэлзэл нь тухайн цаг үеийнхээ сайн хүнийг бэлтгэхэд чиглэгддэг. Энэ эрмэлзэл нь ямарч цаг үед, ямарч хувьслын дараа дахин давтагдах ёстой. Гүн ухаанд нийгмийн хөгжил ороомог маягаар явагддаг гэж үздэг бол энэ өв уламжлал бас л тэр маягаар явагдах ёстой.

Монголчууд үр хүүхэд, ач гуч юугаан бага балчираас нь сайн хүмүүжүүлж, үеэс үед уламжлагдан ирсэн ёс суртахууны эрхэм нандин өв, арга билгийн яндашгүй сан, хүмүүжүүлэх арвин баялаг уламжлалыг хүн бүхэн сурч мэдэж сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хэрэглэхийг зайлшгүй шаардаж байна.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх ухаанд:

“Нутгийг шинжье гэвэл усыг нь шинж,

Хүнийг шинжье гэвэл нөхрийг нь шинж",

"Нүүхийн өмнө нутгаа үз

Буухын өмнө бууриа сонго".

"Намрын цагт шилд бууж

Өвлийн цагт өтөгт бууж

Хаврын цагт хаалт барьж

Зуны цагт зүлгэнд буу" гэж сургадаг нь харуул, манаагаа хаана байрлуулах, хашаа бууцаа хаана барихыг зааж сургажээ.

Түүгээр ч барахгүй эхний хоёр мөрөнд хүнийг таньж мэдэх утга санааг өгүүлээд зогсохгүй шинжиж таньсны үндсэн дээр сайнтай нөхөрлөнө. Түүний сайн сайхан чанараас өөртөө шингээж биеэ хүмүүжүүлнэ гэж сургажээ.

Хүний нинжин сэтгэл, хүмүүнлэг, энэрэнгүй чанарыг нэн тэргүүнд тавьдаг. "Хаан хүний эрдмийн дотор хайрлах сэтгэл нэн эрдэм, хатан хүний 15 эрдмийн дунд төв сэтгэл нэн эрдэм" учир ая эвийг хичээж, шударга сайн үйлд шамд гэж сургасан байдаг.

Хүний сайхан чанар нь хүнийг хүндлэх, хүнтэй зөв харьцах, хууль ёсыг дээдлэн сахих, эх орон ард түмнээ хайрлах, эх болсон газар шороо, дэлхий ээжээ хамгаалах энэ бүхэн бол чухам хүмүүнлэг энэрэнгүй ёс, нинжин сэтгэлд дулдуйдсан юм. Манай ард түмэн энэ талаар олон мянган жилийн сайхан уламжлалтай билээ. Хамгийн наад зах нь газрын хөрсийг онгичиж, хорхой шавьж тэргүүтнийг өртүүлэхгүйг бодож, гутлынхаа хоншоорыг хүртэл ээтэн хийж ирсэн нь учиртай. Мөн усанд сүү цагаан идээ, махны шүүс, цус оруулчих бий, гэж усанд явахын өмнө шанага, халбагаа гялалзтал угааж арчдаг уламжлалтай.

"Удам угсаагаа мэдэхгүй хүн ойд төөрсөн бич лугаа адил" хэмээн үзэж хүн бүр өөрийн уг үндэс, ураг төрлөө сайн мэдэж, үр ач нартаа түүх намтраа хэлж өгдөг. Чингэснээрээ тэр овгийн нэр хүнд үеэс үед сайн сайхан үргэлжлэх болно. Үүнтэй адил манай офицерууд хилийн застав салбарынхаа түүхэн замнал, баатарлаг уламжлалыг хойч үедээ уламжилж түүгээр бахархуулан дуурайх, хүндэтгэн хайрлах, хамт олноо нэгтгэх цаашид зүтгэл гарган хөдөлмөрлөх, их үйлсэд татан оруулах болно.

"Тустай бол хатуу ширүүн үг боловч

Тусган ухаж хайрын үг болгон ав

Тус болохгүй бол магтаал үг боловч

Үнэн баясгах үг хэмээн бүү тооц" гэж Зая бандид

Лувсанпэрэнлэй сургажээ.

Монголчуудын хүүхэдтэй холбоотой нийтлэг түгээмэл

хэвшсэн зан үйл горим нь өнө эртнээс уламжлагдан 19-20 дугаар зууныг хүртэл хадгалагдаж иржээ.

Гэр бүлд шинэ хүн мэндлэх нь их том баяр бөгөөд тэр баярыг дагалдан олон янзын зан үйл ёслол үйлддэг байжээ.

Гэрийн хүмүүжил олгох ёслол нь эрэгтэй хүүхэд аавынхаа хийж бүтээж ярьж хэлж байгаа бүхнийг, эмэгтэй хүүхэд ээжийнхээ бүх л үйл ажиллагааг даган дуурайж хүмүүжил олдог тул хүүхдээ хувийн үлгэр дуурайллаараа хүмүүжүүлэх асар их үүрэгтэй байдаг. Түүнтэй адилаар цэргийн анги салбарт захирагч дарга нар цэргийн албаны бүхий л үйл ажиллагаанд өөрөө үлгэрлэн дууриалал болохоор байх хэрэгтэй.

Гэр бүлийн амьдралд хүүхдийг багаас нь хөдөлмөрт сургахдаа хөлд орохоос нь аргал, түлээ оруулах, ус авах ажилд бага багаар сургаж ирээдүйн хөдөлмөрч хүн болох их замд хөтөлдөг. 4-5 настайд нь мал аж ахуйн ажилд сургадаг тухай. То вангийн сургаалд: "Хүүхдийг хүмүүжүүлэхдээ зарим хүн загнаж сургах гэх юм. Хэдий эцэг эх нь хүүхдээ сургах нь ёс мөн боловч тэр юуг ч мэдэхгүй балчир бөгөөд өвдсөндөө уйлахаас гомдсондоо илүү уйлахыг сонсвол үнэхээр өр өвдөх мэт, бас хүүхдийг гомдуулбаас заяа гомдох хэмээх бөгөөд заяагаа гомдоовоос харин өөрийн биед харамсах болой. Иймийн тулд хүүхдийг загнаж бүү гомдоо. Харин миний хүү сайн гэж хөөргөж бага сага зарахад тустайг юун өгүүлэх. Дараа нь томорч мэдрэл бүрдсэн цагт яахан сургаж ятгахыг эцэг эх нь мэдэх буй заа" гэжээ.

Манайд цэргийн дарга нарын зарим нь цэргийг том дуугаар аашилж загнах, дүрэмдэх явдал мэр сэр байна. Энэ бол хүмүүжүүлэх сайн арга биш. Түүний оронд сайн тайлбарлан ойлгуулж учирлах нь хүнд их зүйлийг бодогдуулна.

Тийм учраас: "Уул морийг зовооно
Уур биеийг зовооно" гэдэг мэргэн үгс гарсан биз.

Ер нь "Эрт босоход нэгийг харж
Орой унтахад нэгийг сонсдог"
"Өөдлөхөд санаж сэрэх
Уруудахад унтаж идэх"

гэх мэт зүйр цэцэн үгсээр үр хүүхдээ сургаж хүмүүжүүлж байсан нь бас л учиртай.

Монголчууд 4-12 насыг бага нас гэж үзээд энэ наснаас нь зүүн гарыг "солгой", баруун гарыг "зөв гар" хэмээн ажил хөдөлмөрт сургах, 6-7 наснаас нь морь унуулж, адуу мал зүслэн таниулах, мал маллуулах арга ажиллагаанд сургадаг байжээ. Тэгвэл одоогийн бага

насны хүүхдийн ажил үгүйлэгдэж, зурагт үзэхээс өөр юмгүй залхуу сул дорой болж өсөж байгаад сэтгэл эмзэглэхээс аргагүй. Монгол ёсонд айл өрхийн гэрийн доторхи хүмүүжил маш дэг журамтай байжээ. Энэ дэг ёс хатуу ёш, эцэг эх нь хүүхэдтэйгээ эелдэг харьцаатай "миний хүү", "миний охин" хэмээн дуудаж тэднийг өрх гэрийнхэн, ахмад хүний үг, сургамжийг сонсож, тэднээр магтуулж, хүндлүүлдэг нийгмийн хэв журмыг дагадаг үзлээс хүмүүжүүлдэг байжээ.

Гэрт баримтлах хорио цээрийг эцэг эх нь өөрсдөө ягштал баримталж үр хүүхдээ түүнд сургадаг байсан нь хожим эцэг эхэд нь сайнаар нөлөөлжээ. Тухайлбал: Гэрт хүмүүс зочлон ирэхэд хүүхдүүд шуугих, гүйдэх, ярианд хөндлөнгөөс оролцох, чагнах нь хориотой байсан байна. Түүгээр ч барахгүй хүүхдийн иддэг хоол нь ч хязгаартай байсан явдал тэдний алс ирээдүйд зөв зүйтэйгээр нөлөөлдөг байна. Хонины толгой чанаад хувааж өгөхдөө тагнайг нь охиндоо "Хавтага сайн хуниарай" "Уран болоорой" гэж өгөх, хүүдээ болохоор нойр, түгшүүр өгөхгүй байх зэргээр ялгаатай байсан байна.

Одоо цагт бид үр хүүхдээ, цэрэг дайчдаа хүмүүжүүлэхдээ цагийн хөгжлийг дагах нь зөв ч оросоор ч юм уу, америкаар биш, монголоор нь хүмүүжүүлэх ёстой.

В.Инжинашийн "Юань улсын мандсан төрийн хөх судар"-т:

"Эр хүн биеэ эдээр чимэхээс

Эрдмээр биеэ чим.

Эхнэр хүн биеэ алтаар чимэхээс

Оюунаар чим." хэмээн улс орны хувь заяанд боловсрол мэдлэг эрхэм болохыг чухалчилж байжээ. Нөгөө талаар улс орон, ард олны нэгдлийг хүчтэй, эв нэгдэлтэй болохыг эрхэмлэж "Таван сумны тухай онолыг домгоор илэрхийлсэн, эв нэгдэлгүй бол юунд хүргэдгийг Жамухын ялагдлаар илэрхийлсэн бус уу.

Мөн түүнчлэн Ишданзанваанжилын бичсэн шүлэг номуудад дарлагч ангийг шүүмжлэн дооглох, эрдэм оюуныг дээдлэн хүндэтгэх,, эд аж ахуйг хайрлан хамгаалах талаар бичсэн нь хойч үедээ сургаалтай байдаг.

Тухайлбал түүний "Галын шашдир" хэмээх нэг бүлэг 3 бадаг шүлэгт:

"Эрхэмлэн хуран /сэрэн/ судлахгүй бол

Энэхэн биений хэрэггүй

Хэрэглэх аргал, уул, модгүй бол

Хэт цахиур галт болор хэрэггүй.

Өчүүхэн мэдсэн эрдмээрээ хөөрвөл

Өөдтэй мэргэд болж үл чадах

Өвч шатаасны өчүүхэн галаар

Өнгөт эрдэнэсийг хайлуулж үл чадах" гэжээ.

Түүний бичсэн: "Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал"-д:

"Учирсан биенийхээ эрхэм чухаг эрдмийг

Онолтой галзууран, согтууран явж

Унтах идэхээр нөгцөөх бол

Оюун үгүй адгууснаас ялгаагүй." гэж сургасныг бид цэрэг дайчдад тайлбарлан ойлгуулах, танин мэдүүлэх ёстой бусуу?

Манайхны зарим нь сурахын оронд биеийн амрыг харж бэлэнчлэх сэтгэлгээгээр цагийг хий дэмий өнгөрөөх явдал байгааг эдгээр мөртүүдээс ухамсарлан ойлгоно гэдэгт найдаж байна.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх ухаанд "Хэрэв тархи толгойд нэг жилийн ажил үйлс багтаж байвал тариа тарь, арван жилийн ажил үйлс багтаж байвал алимны мод ургуул, харин нэг насны ажил үйлс багтаж байвал хүн хүмүүжүүл" гэж сургасан нь чи ямар хүн болсноо мэдээд, ямар ажил хийхийг заан сургажээ.

Ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалд монгол ардын урт богинын дуу, туульс, үлгэр домог, магтаал тодорхой хувь нэмрийг оруулдаг. Тухайлбал: "Өвгөн шувуу хоёр" – уртын дууны гайхамшигт гүн ухааныг та уншаад ойлгох биз. Монгол ардын нэгэн дуунд:

Жороо сайтай морийг болбол

Жолоогий нь дугтраад юугаа хийх вэ.

Зовлон үзээгүй намайгаа болбол

Зодож занчаад юугаа хийх вэ? гэсэн нь танд бас л

сургаалтай биш үү.

Монгол газар шороон дээр өсч өндийсөн хэн боловч монгол ёс заншлаараа өсөхөөс өөр аргагүй бөгөөд монгол мэргэдийн үг сургаалыг сонсож, судлахгүйгээр явах нь хэн болох гээд байгаа нь ч мэдэгдэхгүй байхаас өөр яах вэ?

"Хэрэв чи хүссэн бүхнээ хийж чадахгүй болбоос чадах бүхнээ хий." – гэдэг мэргэн үг ч бий.

Говь нутгаар алдаршсан тавдугаар ноён хутагт Данзанравжаа "Сэтгэлийг амраагч" – хэмээх сургаальдаа ертөнцийн хэрэг, хүний ёс буюу өөрөөр хэлбэл нийт хүн төрөлхтний олонхийн үзэж өнгөрүүлсэн жам ёсыг иш татсан байдаг. Тухайлбал:

"Аяа бас номыг сэтгэлтэйгээ нийлүүлээгүй мэргэд ичиг ичиг

Аяа бас албатаа ялгагч ноёд ичиг ичиг

Аяа бас номыг үл суран элдвийг сурагч банди нар ичиг ичиг

Аяа бас тустай сэтгэлийг бодохгүй өртөг бодогч эмч нар ичиг ичиг

Аяа бас энэ гэмүүд надад бий болбол би ичиг ичиг
Аяа бас хэрэв бусдад их багад бий хэн ч болов ичиг ичиг
гэсэн мөрүүдийг залуучуудад уншиж тайлбарлаж, ойлгуулах
жигшүүлэх соёл хүмүүжлийн олон талт ажил ихээхэн дутагдаж
байна.

Мөн түүний бичсэн:

"Нарны гэрэл хурц болоход

Үүлгүй бол нэн сайн

Насны багад эрдэм сурахад

Залхуугүй бол бүр ч сайн" – хэмээн сургасан нь хойч үедээ
захисан томоохон сургамж гэхээс өөрцгүй.

"Болгоомжгүй хэлсэн үг булзаарахад төвөгтэй

Бодолгүй зөвшсөн зөвшил эвдрэхдээ хэврэг

Давсны амт шорвог ч идээний амтанд найртай

Үнэн үг хатуу ч хэтийн явдалд тустай"

гэсэн сургамжит мөрүүдийг хүн бүгд уншиж судалж, сурталчлах
түүгээр хүмүүжүүлэхэд ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалын
гол зорилго оршино.

Монгол хүн дээр үеэс эхлэн нарыг алттай, сарыг мөнгөтэй,
усыг чандмань, уулыг аавтай зүйрлүүлж хайрлан хамгаалж, газар
орныг тухайн баялгаар нь Эрдэнэт, Баян, Рашаант, шохойт гэх буюу
тэнд нутагшсан ан амьтдаар нь Ёл, Ямаат, Хар аргалант, хөшөө
дурсгалаар нь Бичигт, Хөшөөт, Бурхант гэх зэргээр нэрлэж байгаль
дэлхийгээ хайрлан шүтэж, уулын мод бутыг огтлох, ан амьтныг алж
устгахыг цээрлэж байсан өв уламжлалаа судалж, мэдэхгүйгээр
Монгол газар нутаг дээр оршин суух эрхгүй, хамт байх нөхцөл ч
байхгүй. Тийм ч учраас монгол ёс уламжлалаа урьд үеэсээ өвлөн
авч хүмүүжих нь хойч үеийн үүрэг гэдгийг цэргийн албан хаагчид, ер
нь хэн боловч ойлгох ёстой.

Иймийн тулд эртний "Оюун түлхүүр" номонд:

"Шашинд дургүй сахилтнаас

Сайн сүжигт хар хүн дээр

Төр ёс үл мэдэх хатнаас

Ичгүүр үл мэдэх шивэгчин дээр

Хадгалж үл мэдэх хөвүүнээс

Халамжит сайн боол дээр гэж сургасан бөлгөө.

Монгол зан заншилд хүндэтгэлийн үгийг ихээр хэрэглэдэг.
Энэ тухай эрдэмтэн Чой.Лувсанжав "Одоогоор мэдэгдэж байгаа 2000
гаруй тийм үг байна гэсэн байдаг."

Монгол хүн хойч үеэ сурган хүмүүжүүлэхдээ зүйр цэцэн үгийг

ихээр хэрэглэдэг нь чихэнд сонсголонтой, сэтгэлд таатай байдаг.

Хий дэмий үглэснээс

"Аяганы хариу өдөртөө

Агтны хариу жилдээ"

"Эрхийг сурахаар

Бэрхийг сур"

"Үлгэргүй эхээс

Ичгүүргүй хүү төрнө"

"Урагшгүй амьтныг усан дотроос түймэр

ноцно"

"Хараалчийн хүү хараалч

Худалчийн хүү худалч"

"Залхуугийн гэрт түлшгүй

Залгидгийн гэрт хоолгүй"

"Сайн явбал бүтнэ

Сажилж явбал хүрнэ"

"Номыг нь сурахгүй бол

Номхоныг нь сур"

"Хүн нэрээ тогос өдөө"

"Сайныг дагавал сарны гэрэл

Мууг дагавал могойн хорлол"

"Ах нь хэлж дүү нь сонсодог"

"Айсан хүнд аргал хөдөлнө"

"Гэмт хүн гэлбэлзэнэ

Дайрт морь дайвалзана"

"Эрдэмтэй бол далай

Эрдэмгүй бол балай"

"Ус үзээгүй гутал тайлах

Уул үзээгүй хормой шуух"

"Ажил хийвэл дуустал

Давс хийвэл уустал" гэх зэргээр зүйрлэж

хэлэхэд л бүгд ойлгогдоно. Гагцхүү эдгээрийг сургаж хүмүүжүүлэх ажилд ашиглах нь маш ховор байна.

"Уцаар ихтийн хараах нь

Ухаан муутын аашлах нь" гэгч л болоод байна.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх ном сургаалд хүнээр хүн хийх 10 зарчим байдгийг заахдаа:

1. Хүүхдийг хайрлах

2. Хүүхдийг халамжилж хамгаалж явах

3. Хүүхдэд сайн үлгэр жишээ үзүүлэх

4. Хүүхэдтэй байнга хамт ажиллах /дагуулах/
5. Хүүхэдтэй тоглож, наадаж байх
6. Хүүхдэд амьдрах ухааныг зааж сургах
7. Хүүхдэд өөрийг нь хүчийг зөв ойлгуулах
8. Хүүхдийг чих зөөлөнтэй болгон хүмүүжүүлэх
9. Хүүхдэд амьдралын эрээн барааныг бүрэн ойлгуулах
10. Хүүхдийг дурсах юмтай амьдарч сургах

Эдгээр 10 зарчмыг цэргийн анги салбарт хэрэгжүүлж цэргийг сургаж хүмүүжүүлэхэд болохгүй юм байхгүй.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалд хойч залуу үеийг ажил, хөдөлмөрт сургахдаа өөрсдийн бодол санаагаар хийж бүтээх явдал зайлшгүй хэрэгтэйг зааж сургасан байдаг.

Тухайлбал: “Хүний толгойгоор нисэхээр

Өөрийн толгойгоор өнхөр” гэжээ.

Хүнийг таньж мэдэх арга, хүний ажил үйлсийн тухай, ажлын үр дүнгийн талаар, хүний хуурамч зангийн тухай, хүний амьдралын талаар зааж сургасан олон сайхан сургааль байдаг. Тухайлбал:

“Хүнийг мэдье гэвэл зан аашийг нь мэд

Хүүхдийг мэдье гэвэл тоглоомыг нь үз”

“Алба мэдэхгүй ноён улсын чөтгөр

Ааш муутай хүн аяны чөтгөр”

“Амин хувийн ашиг өвсний шүүдэртэй адил

Ард олны ашиг өндөр уултай адил”

“Булгийн ус оргивч хүйтэн

Буруу санаат инээвч худалч”

“Бусдын эрхээр жаргахаар

Өөрийн эрхээр зов” гэсэн байхад

Хүний зовлон жаргалаар тоглодог, харгис дээрэнгүй, гаднын гаж буруу санаатанг залуу хүмүүст ойлгуулахаар

“Зуд болоход нохой зорлно

Зовлон болоход лам таргална”

“Ирэхдээ зүүний сүвэгчээр

Буцахдаа дааман хаалгаар багтахгүй”

“Монгол хүн билгээрээ

Төвд хүн шидээрээ

Хятад хүн наймаагаараа” гэж онож хэлсэн үгийг бид хэлж ярихгүй юм бол мартаж үгүй болох аюултай. Ийм зүйрлэл хэнд ч ойлгомжтой.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалд хүүхэд багачуудад цээрлэх 6 зүйл гэж байжээ. Үүнд:

1. Гашуунаар бүү тэтгэ.
2. Амттанаар бүү тэтгэ.
3. Өнгөнд бүү шунуул.
4. Тансагт бүү умбуул.
5. Улайг бүү үзүүл.
6. Нойронд бүү автуул

гэж сургасныг өнөөгийн эцэг эхчүүд мэдэх хэрэгтэй. Бидний хүүхдүүд эдгээр 6 зүйлийг яаж цээрлэж байна гэдгийг хүн бүр бодож сэтгэх ёстой юм.

Хүн өөрийн хүчээр жаргах ёстойгоос биш, эцэг эхийн хүчээр жаргавал өөдтэй хүн болохгүй. Энэ тухай "Оюун түлхүүр" хэмээх сургаалд:

"Муу хүн нэг ч эрдэмгүй болбоос

Дээрээ шүдтэйгээс бус үхэр лугаа адил

Сургаал үл сонсох бөгөөд гагцхүү цадахыг хүсэгч хүн

Үсгүйгээс бус гахай лугаа адил" гэжээ.

Эрдэм ном боловсрол олж авахын зайлшгүйг олон суут эрдэмтэн мэргэд хойч үедээ захиж үлдээснийг бид тэдний сургаал, номоос уншиж зааж сургах хэрэгтэй.

Л.Агваанхайдав "Ном үзэхийн ухаан төрөлгүй хорин нас өнгөрөөд, үзэхийн ухаан төрсөөр хорин нас өнгөрөөд, өнөө маргааш гэсээр ахин хорин нас өнгөрөөд адаг сүүлд нь хүний ертөнцөөс гар хоосон буцна" гэжээ.

Н.Ишданзанванжил

"Өчүүхэн мэдсэн эрдмээр хөөрөгдвөл

Өөдтэй мэргэн болж үл чадна

Өвс шатсаны өчүүхэн галаар

Өнгөт эрдэнэсийг хайлган үл чадах"

Онходын Жамъян "Эрдэм сурахыг хүсвэл ... өөрөөсөө дээш эрдэмтэй ахас ихэс хүмүүсээс эмээн шантраад мэдэхгүй зүйлээ асууж лавлаж чадахгүй хоцрохын халхавч, үеийн нөхдөөс мэдэхгүй зүйлээ асуухаас ичиж өөрөө мэддэг дүр гарган мэдэхгүй хэвээр хоцрох нэрэлхэхийн халхавч, мэдлэг багатай буюу өөрөөс дорогш хүмүүсийг юу ч мэдэхгүй гэж басамжлан үл тоож асуун мэдэхгүй хэвээр хоцрох дээрэнгүйн халхавч. Эдгээр шантрах, нэрэлхэх, дээрэлхэх, ухамсаргүйн гурван халхавчийг ... хаяж, ахмадаас халшралгүй асууж лавлаж мэд! Өөрийгөө мэдэхгүй гэж хэлэхээс ичилгүй үеийн хүмүүсээс асууж лавлан мэд! Бага хүмүүсийг гололгүй асууж лавлаж мэд!" гэжээ.

Хар үхэрт хөвүүний туужид

"Өчүүхэн насанд эрдэм сурвал
Шинэ ургах наран саран мэт
Дунд насанд сурсан эрдэм
Үдийн наран мэт
Өтөлтөл эрдэм эс сурваас
Харанхуй шөнө мэт" гэжээ.

Энэ бүх сургаалын эцэст

"Хашийг цоолборлохгүй бол

Сав болж бүтэхгүй

Хүнийг сургахгүй бол

Ёсыг мэдэхгүй" гэсэн байдаг.

Ингэж олон зууны туршид эрдэмтэн мэргэдийн хийж бүтээсэн зүйлийг ард түмний ёс заншлыг хойч үе нь өвлөн авахааргүйгээр хөгжинө гэдэг үндэсгүй мод ургахгүйтэй адил юм.

Тиймийн учир ард түмнийхээ захиж үлдээсэн, уламжилж авч явах ёстой эрхэм нэгэн зүйлийг товчхоогоор дамжуулахыг хичээж чадан ядан бичив.

Дэд профессор Н.Пүрэвсүрэн



Завтай цагтаа

Бодлого №3

Хилийн хорооны хэсэгт $n=30$ удаа хил зөрчих оролдлого хийгдсэнээс, 27 тохиолдолд хил зөрчигчдийг саатуулсан. $\alpha=0.95$ үеийн хил зөрчигчдийг илрүүлэн саатуулах магадлалыг олж, энэхүү магадлалын найдварт байдлын өгөгдсөн завсрыг ол!

*Бэлтгэсэн: магистр, дэд хурандаа Д.Нямдорж
магистр В.Бат-Эрдэнэ*